

**"БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК" ОНӨТҮГ  
2019 ОНЫ 07 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЕЛЭЛТ**

2019 оны 07 дугаар сарын 30

Багануур дүүрэг

№	Үндэслэл	Хийсэн ажлын биелэлт	Гүйцэтгэлийн хувь
1	"БҮТП" ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 17.1.	<p>Барилга, хот байгуулалтын яам нь Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төсөл боловсруулах БХБЯ-ЗҮ-2017/011 дугаартай ажлын 2018 оны 2018/10 дугаартай гэрээний хугацааг 2019.06.28-ны өдрийн 2019/120 дугаартай нэмэлт, өөрчлөлт, сунгалтын нөхцөлөөр 2019.07.30-ны өдөр хүртэл сунгасан.</p> <p>Мөн Барилга, хот байгуулалтын яам нь 2019.07.05-ний 03/2680 дугаар албан бичгээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамд БҮТП-ийн ТЭЗҮ-тэй холбоотой баримт материалыг авч, Эрчим хүчний яаманд БҮТП-ийн ТЭЗҮ-г Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шаардлагатай цахилгааны техникийн нөхцөлийг олгуулахаар 2019.07.17-ны 03/2798 дугаар албан бичгийг хүргүүлээд байна.</p> <p>Инженерийн шугам сүлжээний зураг төслийн хувьд цахилгаан хангамжаас бусад зураг төсөл боловсруулагдаж дүүргийн дэд бүтцийн хангагч байгууллагуудтай 2019.07.23-ний өдөр зөвшилцөж баталгаажуулсан.</p> <p>Ерөнхий төлөвлөгөөг 2019 оны 08 дугаар сарын 02-ны өдөр НИТХ-ын Тэргүүлэгчидийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна.</p>	100%
2	"БҮТП" ОНӨТҮГ-ын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 6.5	Манай хороо – Миний гудамж аяныг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллаж, тайланг дүүргийн ЗАА-д хүргүүлсэн.	100%



3	Багануур дүүргийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/147 дугаар захирамж	Байгууллагын үйл ажиллагааг шалган зааварласан ажлын хэсгийн зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллаж удирдлагад танилцуулсан.	80%
4	Нийслэлийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 30-ны А/518 дугаар захирамж	Байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн Бэлтгэл ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж, дүүргийн Архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн Ц.Түвшинжаргалтай уулзаж архивын баримт материалуудаа шалгуулан зөвлөгөө авсан.	100%
5	"БҮТГ" ОНӨТҮГ-ын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.18	Гүйцэтгэл, нийцлийн аудитын хэлтэст 2018 оны бодлогын баримт бичиг болон санхүүгийн тайланг шалгуулж, дүгнэлт гаргуулан зөвлөмж авсан бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлж эхэлсэн.	100%
6		Байгууллагын эхний хагас жилийн санхүүгийн тайланг гаргаж хугацаанд нь хүргүүлэн ажилласан бөгөөд байгууллагын веб сайтад байршуулсан.	100%
7		Шилэн дансанд байгууллагын хагас жилийн санхүүгийн тайланг хугацаанд нь байршуулсан.	100%
8		Байгууллагын 2020 оны төсвийн төсөл, 2021-2022 оны төсвийн төсөөллийг боловсруулж хүргүүлсэн бөгөөд төсвийн төлөвлөлтийн мэдээллийн цахим системд шивж оруулахаар төлөвлөж байна.	100%
9		Төсвийн гүйцэтгэлийн тайлан мэдээг 07.03-ны дотор гаргаж хүргүүлсэн.	100%
10	Нийслэлийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/619 дүгээр захирамж	Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн захиргаа, нэгдсэн үйлчилгээний төвийн барилгын зураг төслийг хийлгэх ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргаар 1067 м.кв газрын захирамжийг гаргуулахаар Газар эзэмших, ашиглах эрх баталгаажуулах үйлчилгээний бүртгэлийн хуудасны дагуу холбогдох материалуудыг бүрдүүлж нэг цэгийн үйлчилгээнд хүлээлгэн өгсөн. Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дүүрэг хариуцсан мэргэжилтэн Г.Анхзаяа болон Б.Батбаяртай утсаар холбогдож ажлын явцыг тодруулсан. 8 дугаар сарын эхээр болох Газар, барилгажилтын мэргэжлийн зөвлөлийн хурлаар манай асуудлыг оруулахаар бэлтгэл ажлыг хангасан байна.	100%



		<p>Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын мэргэжилтэн Түвшинбилэгтэй барилгын зураг төсөл боловсруулагдах газар дээр очиж танилцуулан зөвшилцсөн. Мөн захиргаа, нэгдсэн үйлчилгээний төвийн зургийн даалгаварт тусгах саналыг боловсруулж нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт 2019.07.23-ны өдрийн 113 дугаар албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Зураг төсөл боловсруулах ажил эхэлж байгаатай холбогдуулан дүүргийн дэд бүтцийн байгууллагуудаас тухайн газарт инженерийн шугам сүлжээний газар дээрх болон далд шугам сүлжээний тодруулга авах ажлыг зохион байгуулж байна.</p>	
11	Нийслэлийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/619 дүгээр захирамж	Нийслэлийн Байгаль орчны газрын Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн хэлтэст ажлын даалгавар боловсруулж өгөх тухай албан бичиг хүргүүлсэн бөгөөд 2019.07.16-ны өдрийн 02/956 дугаартай хариу бичгээр БОАЖЯ-аас ирүүлсэн Ерөнхий дүгнэлтэд үндэслэн ажлын даалгаврыг боловсруулах чиглэл өгсөн тул Ажлын даалгаврыг боловсруулж батлан нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт хүргүүлсэн.	100%
12	"БҮТП" ОНӨТҮГ-ын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.2	Багануур дүүргийн Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулах Паркийн тулгамдсан асуудлуудын танилцуулга болон холбогдох материалуудыг бэлтгэж удирдлагад танилцуулсан.	100%
13	МУ-ын Ерөнхий сайдын 2019 оны 52 дугаар захирамж	МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого болон уг бодлогыг 2020-2025 онд хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөний төсөлд салбарын хэмжээнд тодорхой зорилт дэвшүүлэн, санал боловсруулсан.	100%
14	Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 214 тоот тогтоол	Монгол Улсын "Хүнд үйлдвэрийн хөгжлийн үндэсний хөтөлбөр" батлагдсантай бөгөөд "Хүнд үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд санал боловсруулж, зөвлөгөөнд оролцсон.	100%
15	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас 2019.06.25-ны 02/811 дугаар албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийг нийт албан хаагчдад танилцуулж, танилцах хуудас хөтөлсөн.	100%



	авах тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт		
16	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 47 дугаар тушаал	Байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөө, албан хаагч нарийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлагдсан аргачлал, зөвлөмжид нийцэж байгаа эсэхийг хянан үзэж удирдлагад танилцуулсан бөгөөд батлагдсан аргачлал, зөвлөмжид нийцүүлэн шинэчлэн боловсруулж танилцуулах чиглэл авсан.	100%
17	Багануур дүүргийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/220 дугаар захирамж	Ерөнхий менежерийн 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/145 дугаар тушаалын дагуу Харшлын эсрэг хамтдаа уриатай "Шарилжгүй Улаанбаатар 4" аяны 1 дүгээр үе шатыг 2019.07.03 болон 2019.07.29-нд дүүргийн хэмжээнд зохион байгуулсан тул хуваарилсан газарт зориулалтын дагуу хайчлан, устгаж тайланг дүүргийн ЗАА-д хүргүүлсэн.	100%
18	Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны тушаал	Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн баталсан хуваарийн дагуу Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан 2019.07.05-ны өдөр заасан байршил болох дүүргийн Хүүхэд залуучуудын паркийн хашааны гадна талын хог хаягдлыг цэвэрлэж, тайланг ЗАА-нд хүргүүлсэн.	100%
<b>Нэмэлт ажлууд</b>			
19	Багануур дүүргийн 40 жилийн ойн номонд оруулах материалыг бэлтгэж удирдлагад танилцуулсан.		100%
20	Багануур дүүргийн нийгэм, эдийн засгийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн саналыг боловсруулж удирдлагад танилцуулсан.		100%
21	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2016-2019 оны эхний хагас жил хүртэлх хугацааны тайлан болон нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн эхний хагас жилийн биелэлтийг тус тус гаргаж ХШ,ҮХ-т хүргүүлсэн.		100%
22	Байгууллагын 2019 оны эхний хагас жилийн бичмэл тайланг гаргаж нийслэлийн ХШ,ҮХ-т хүргүүлсэн.		100%
23	Багануур дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн Амаржаргалтай уулзаж ажлын байрны хоёр сул орон тооны зарыг үргэлжлүүлэн байгууллагын веб сайтад байршуулах тухай санал болон ажлын байрны захиалгыг өгсөн.		100%
24	Нийслэлийн Шинжлэх Ухаан Үйлдвэрлэл, Инновацийн Газарт байгууллагын долоо хоногийн төлөвлөгөө, тайланг тогтмол хүргүүлэн ажиллаж байна.		100%

ХЯНАСАН:



Ч.ЭЛБЭГСАЙХАН

“Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын дарга

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

Б.МИЧИД-ЭРДЭНЭ

Ахлах мэргэжилтэн